



АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь ББСБ-ын удирдлага, ажилтнууд нь хувийн ашиг сонирхол болон Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль, хөдөлмөрийн дотоод дүрэм, ажилтны ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар ББСБ-ын үйл ажиллагааг тэгш эрх, хууль ёсны зарчимд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж ББСБ-ын ил тод, итгэл даах байдлыг хангахад оршино.

1.2. Энэхүү дүрэм нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль, хөдөлмөрийн дотоод дүрэм, хөдөлмөрийн гэрээ, ББСБ-ын бусад дүрэм, журамтай нийцсэн байна.

1.3. ББСБ-ын ажилтны ашиг сонирхлын дүрмийг ББСБ-ын удирдлага, нийт ажилтнууд даган мөрдөж, сахин биелүүлнэ.

1.4. Энэхүү дүрэмд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.4.1. “Хувийн ашиг сонирхол” гэж ББСБ-ын ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцад өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;

1.4.2. “Ашиг сонирхлын зөрчил” гэж ББСБ-ын ажилтан ажил үүргээ хэрэгжүүлэх үедээ хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын үүднээс Монгол Улсын хууль тогтоомж, ББСБ-ын Хөдөлмөрийн дотоод журам болон бусад журмыг зөрчих, албан тушаалаа урвуулан, эсхүл хэтрүүлэн ашиглаж өөрт болон өөрийн танил, гэр бүлийн гишүүн, төрөл, садан, найз нөхдөд давуу байдал бий болгох болон албан үүргээ тэгш шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц бусад нөхцөл байдлыг;

1.4.3. “Бэлэг” гэж ББСБ-ын ажилтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг;

1.4.4. “Хандив” гэж ажилтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсвэл ББСБ-аас санал болгож буй хөнгөлөлт, хадгаламж болон зээлийн хүүнээс хэт бага үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэхийг;

1.4.5. “Хээл хахууль” гэж ажилтанд өөрийн хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд бэлэг сэлт, хандив, шан харамж, мөнгө, эд хөрөнгө олгохыг;

1.4.6. “Хамаарал бүхий этгээд” гэж тухайн ББСБ-ын ажилтны эцэг, эх, төрсөн ах, эгч,

дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;

1.4.7.“Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж ББСБ-ын ажилтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;

1.4.8.“Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж тухайн ББСБ-ын ажилтны өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг;

ХОЁР. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

2.1.ББСБ-ын удирдлага, ажилтнууд ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх хүрээнд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

2.1.1.ББСБ-ын эрх ашгийг ямагт хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоос дээгүүрт тавьж, ажил үүргээ гүйцэтгэх явцдаа бусдын нөлөөнд авталгүй ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзаж, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдлыг бий болгохгүй;

2.1.2.ББСБ-ын эрх, ашиг сонирхлын эсрэг аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал бий болгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, бусад хангамж эдлэх зэрэг үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх.

2.2.ББСБ-ын удирдлага нь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авах үүрэгтэй. Үүнд:

2.2.1.Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дүрмийг тогтоож, мөрдүүлэх;

2.2.2.Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу ажилтнуудаас авах, бүртгэх, хянан шалгах үйл ажиллагааг Ёс зүйн хороо хариуцан ажиллах;

2.2.3.Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх.

2.3.Ажилтан нь ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдлын талаар болон үүнтэй холбогдох аливаа мэдээллийг нуун дарагдуулахгүйгээр байгууллагын удирдлага, эсвэл дотоод сүлжээн дэх “Шүгэл үлээх шугам”-аар мэдээлэх үүрэгтэй.

2.4.Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл нь бодит үнэнд тулгуурласан, нотлох баримттай байна. ББСБ-ын бодлого, дүрэм зөрчсөн, хууль бус үйл ажиллагаа, ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдээллийг нотлох баримтын хамт Ёс зүйн хороонд ирүүлнэ.

2.5.Мэдээллийн нууцыг задруулахгүй хадгалах ба ББСБ мэдээлэгчийг нууцалж, хамгаална.

2.6.Ажилтан ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ.

ГУРАВ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСГЭХГҮЙ БАЙХ ХЭМ ХЭМЖЭЭ

3.1.ББСБ-ын ажилтан бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ажил эрэлхийлж байгаа бол энэ тухай удирдлагадаа мэдэгдэх.

3.2.Ажилд орох хүсэлтэй иргэнтэй хамаарал бүхий этгээд буюу ойр дотны харилцаатай, гэр бүлийн гишүүн, төрөл, садан, найз бол энэ тухайгаа холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, тус иргэний ажилд авах асуудлыг шийдвэрлэхэд оролцохгүй байх.

3.3.ББСБ-ын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн үзэл бодлын үүднээс сөргөөр тайлбарласан, олон нийтийн хүртээл болгоогүй аливаа мэдээлэл болон ажилтнуудын цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, байгууллага болон хувь хүнтэй холбоотой мэдээ, мэдээллийг бусдад тараахгүй байх.

3.4. Албан тушаалын давуу тал, боломжийг хувийн зорилгод ашиглахгүй байх.

3.5. Албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө үнэ бүхий мөнгөн хөрөнгө, эд зүйл, бэлэг дурсгал, шагнал урамшуулал зэрэг хуулиар хориглосон бараа материалыг иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас авахгүй байх.

3.6.Өөрийн танил, дотны найз нөхөд, гэр бүл, төрөл садангийн хүмүүс ажиллаж байгаа ББСБ-ын нэгжид хяналт шалгалт хийх, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, шалгаруулалтад оролцох, шалгаруулагчийн шийдвэрт нөлөөлөх, үйлчилгээ авах, гэрээ хэлцэл байгуулах, байгууллагын нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг хориглоно.

3.7.Албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хамт ажилладаг ажилтнуудыг болон бусдыг дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглоно.

3.8.Ажил үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу хяналт тавих албан тушаалтан нь гэр бүл, төрөл садангийн хүнтэй нэг газар, хэлтэс, салбарт хамт ажиллах, түүнийг албан тушаалд дэвшүүлэх, сургалтад сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнд оролцох, хүний нөөцийн ажилтанд нөлөөлөхийг хориглоно.

3.9.Ажилтан ажил үүргийнхээ дагуу олж авсан мэдээллийг санаатай болон болгоомжгүйгээр задруулах, ажлын бус зорилгоор ашиглахгүй байх.

3.10.Ажилтан нь албан тушаалын давуу талаа ашиглан бусдын нэр хүндэд халдах, хууль бус томилгоо, ажил үүргийн хуваарилалт хийх, үнэлгээ дүгнэлт өгөх зэргээс зайлсхийх, хамт олны дунд таагүй уур амьсгал үүсгэх аливаа үйлдэлд оролцохгүй, хөхүүлэн дэмжихгүй байх.

3.11.Ажилтан нь ашиг сонирхлын зөрчилтэй холбогдсон аливаа шийдвэр гаргах,

өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгохтой холбоотой үйлдэл хийхгүй байх.

3.12. Ажил үүргээ хэрэгжүүлсний төлөө харилцагч болон хамтран ажиллагч байгууллага хувь хүнээс шан харамж, хээл хахууль авах, өгөх, зуучлахыг хориглоно.

ДӨРӨВ.ХАРИУЦЛАГА, БУСАД

4.1. ББСБ-ын ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх дүрмийг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах чиг үүргийг “Ёс зүйн хороо” хэрэгжүүлнэ.

4.2. Ашиг сонирхлын зөрчилтэй холбогдсон хэлэлцэх асуудлыг Ёс зүйн хороогоор шийдвэрлэхдээ Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдлагын хорооны гишүүд болон тухайн асуудалд холбогдох ажилтан эсвэл ажилтнууд ашиг сонирхлын зөрчлийн талаар тайлбарыг гарган гарын үсэг зурж баталгаажуулна.

4.3. Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, ББСБ-ын хөдөлмөрийн дотоод журам, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад акт болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн ББСБ-ын ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

4.4. Хэрэв бусдын нэр хүндийг санаатайгаар унагах, хувийн сэдлээр худал мэдээлэл өгсөн бол мэдээлэгчид сахилгын арга хэмжээ ногдуулна.

4.5. Ажилтны ашиг сонирхлын зөрчлийн шинж байдал, хор уршиг, нийгэмд болон байгууллагад учруулсан хохирлын хэмжээ, анх буюу удаа дараа үйлдсэн зэргийг харгалзан Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлд заасан сахилгын шийтгэлийн аль нэг /ажлаас халах хүртэл арга хэмжээ/-ийг ногдуулахыг Ёс зүйн хорооны дүгнэлтийг үндэслэн Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэрээр шийдвэрлэнэ.

4.6. Сахилгын шийтгэл ногдуулсан тухай тушаалыг тухайн ажилтны хувийн хэрэгт хавсаргана.

“ЖЭТФИНАНС ББСБ” ХХК